



Сэдэв: Тооны хуваагдах шинж

Математик 6-р анги



Сэргээн санах даалгавар:

1. $-8 + 39 =$

2. $-8 + (-24) =$

3. $33 - 55 =$

4. $-33 - 67 =$

5. $-27 - (-13) =$

6. $-81 \times (-13) =$

7. $-80 \div 16 =$

Сэргээн санах даалгавар:

1. $-8 + 39 = 31$

2. $-8 + (-24) = -32$

3. $33 - 55 = -22$

4. $-33 - 67 = -100$

5. $-27 - (-13) = -27 + 13 = -14$

6. $-81 \times (-13) = 1053$

7. $-80 \div 16 = -5$

Үлдэгдэлтэй хуваах

$25 \div 7 = 3$ (үлд4) үүнийг математик хэлээр $25 = 7 \times 3 + 4$ бичнэ

a тоог b тоонд хуваахад c оногдоод r үлдсэн бол томъёо нь:

$$a = b \times c + r$$

Үүнд: a – хуваагдагч
 b – хуваагч
 c – гүйцэт биш ногдвор
 r – үлдэгдэл $0 \leq r < b$

Жишээ: 9-д хуваахад 3 үлддэг, 11-д хуваахад мөн 3 үлддэг хамгийн бага тоог ол.

Бодолт:
$$\begin{array}{l} 9n + 3 \\ 11n + 3 \end{array} \Rightarrow 99n + 3 \Rightarrow \text{хамгийн бага тоо нь } 99 + 3 = \mathbf{102}$$

Нийлбэрийн хуваагдах шинж

Нэмэгдэхүүн тус бүр ямар нэгэн тоонд хуваагддаг бол нийлбэр нь хуваагдана.

32 нь 4 – д хуваагдана

16 нь 4 – д хуваагдана

40 нь 4 – д хуваагдана

Иймээс $32 + 16 + 40$ нийлбэр 4 - д хуваагдана.

Үржвэрийн хуваагдах шинж

Үржигдэхүүнүүдийн аль нэг нь өгөгдсөн тоонд хуваагдаж байвал үржвэр нь уг тоонд хуваагдана.

$13 \times 55 =$ үржвэр 11 – д хуваагдана. Учир нь $55 \div 11 = 5$

$844 \times 317 =$ үржвэр 2 – т хуваагдана. Учир нь $844 \div 2 = 422$

Тооны хуваагдах шинж

2-т хуваагдах тооны шинж

Бүх тэгш тоо 2-т хуваагдана.

Жишээ: 35, 54, 120, 192, 31, 16, 28

Эдгээр тоонуудаас 2-т хуваагдах тоог ялган бич.

Бодолт: 54, 120, 192, 16, 28

3-т хуваагдах тооны шинж

Хэрэв тооны цифрүүдийн нийлбэр 3-т хуваагдаж байвал уг тоо 3-т хуваагдана.

Жишээ: $\overline{*8651}$ тоо 3-д хуваагдаж байхаар * -ны оронд тохирох тоо бич.

Бодолт: $* + 8 + 6 + 5 + 1 = * + 20$

$* = 1, 4, 7$ **18651, 48651, 78651** тоонууд 3 – д хуваагдана.

4-д хуваагдах тооны шинж

Хэрэв тооны сүүлчийн хоёр оронгоос бүтсэн тоо 4-д хуваагдаж байвал уг тоо 4-д хуваагдана.

Жишээ: 4-д хуваагддаг гурван оронтой тоо тус бүр 5-г бич.

Бодолт: 100, 108, 112, 116, 128

Тооны хуваагдах шинж

5-д хуваагдах тооны шинж

0 ба 5-аар төгссөн бүх тоо 5-д хуваагдана.

Жишээ: 0, 9, 5 цифр оролцсон гурван оронтой 5 – д хуваагддаг бүх тоог бич.

Бодолт: 95**0**, 90**5**, 59**0**

6-д хуваагдах тооны шинж

Хэрэв тоо 2 ба 3 - д зэрэг хуваагддаг бол 6-д хуваагдана.

Жишээ: $\overline{5162*}$ тоо 6 – д хуваагдахаар * –ын оронд тохирох цифр тавь.

Бодолт: 1) $5 + 1 + 6 + 2 + * = 14 + *$

$* = 1, 4, 7$ үед 3 – д хуваагдана

2) Сүүлийн орон тэгш тоо байна

(3-д хуваагдах шинж)

(2-д хуваагдах шинж)

Хариу: **51624**

Тооны хуваагдах шинж

8-д хуваагдах тооны шинж

Хэрэв тооны сүүлчийн гурван оронгоос бүтсэн тоо 8-д хуваагдаж байвал уг тоо 8-д хуваагдана.

Жишээ: Дараах тоонуудаас 8-д хуваагдах тоонуудыг ялган бич
7000, 1258, 176, 35687016, 3452, 45624

Бодолт: 7**000**, **176**, 35687**016**, 45**624**

9-д хуваагдах тооны шинж

Хэрэв тооны цифрүүдийн нийлбэр 9 -д хуваагдаж байвал уг тоо 9 -д хуваагдана.

Жишээ: 1 – ээс 9 хүртэлх тоог цуварган бичээд, араас нь 9 – өөс 1 хүртэлх тоог залгуулан бичив. Үүсэх тоо 9 – д хуваагдах уу?

Бодолт: 123456789987654321 $(1 + 2 + 3 + 4 + 5 + 6 + 7 + 8 + 9) \times 2 = 90$
 $90 \div 2 = 45$ тул 9 – д хуваагдана.

10-д хуваагдах тооны шинж

0-ээр төгссөн бүх тоо 10 – д хуваагдана.

Жишээ: 105**0**, 345**0**, 31**0**, 234567**0**

11-д хуваагдах тооны шинж

Олон оронтой тоогоо хойноос нь 3,3-н оронгоор таслаад сондгой байрлалд байгаа тоонуудыг нэмнэ. Тэгш байрлалд байгаа тоонуудыг нэмнэ. Ихээс нь багыг хасахад гарах тоо 11-д хуваагдаж байвал уг тоо хуваагдана.

Жишээ: 7836494118 гэсэн тоо 11 – д хуваагдах уу?

Бодолт: 7'834'494'118

$$7 + 494 = 501 \quad 834 + 118 = 952$$

$$952 - 501 = 451$$

$451 \div 11 = 41$ хуваагдаж байгаа тул 7836494118 тоо 11 – д хуваагдана.

Бодлого дасгал

1. Луутай номны 28-29 хуудасны № 1, 3, 7, 11, 15, 17, 19
2. Луутай номны 30-31 хуудасны № 2, 4, 6
3. Луутай номны 33-35 хуудасны
№ 3, 5, 7, 11, 15, 17, 19, 21, 23, 25, 27, 29



Гэрийн даалгавар:

1. Луутай номны 28-29 хуудасны № 4, 14, 18
2. Луутай номны 33-35 хуудасны
№ 4, 6, 8, 12, 14, 16, 18, 22, 24, 26, 28, 30

Нийт 15 бодлого

